



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№92 /311/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.23

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ШИЛДЭГ ЯАМААР ШАЛГАРЛАА



Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу яамд болон аймаг, нийслэлийн тухайн жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын хуралдаанаар дүнг хэлэлцүүлж, ажил үйлсээрээ тэргүүлсэн яамдыг шалгаруулдаг юм. Батлан хамгаалах яам нь 2021 онд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт болон шударга байдлын түвшний үнэлгээ зэрэг 8 үзүүлэлтээр манлайлав. Ийнхүү Монгол Улсын төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтээрээ 2021 оны шилдгээр шалгарсан БХЯ-ны шагналыг Монгол Улсын сайд, Хэрэг Эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт гардуулан өгсөн юм.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ТЭМЦЭЭНД 12 БАЙГУУЛЛАГЫН 800 ГАРУЙ АЛБА ХААГЧ ОРОЛЦОЖ БАЙНА

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор” тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд өчигдөр эхэллээ. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг энэхүү тэмцээний нээлтийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга н.Хадбаатар нарын Зэвсэгт хүчин, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ болон Дотоодын цэргийн штаб, ТЕГ, ТТХГ, ШШГЕГ, УХБХИС, ДХИС-ийн удирдлага, тамирчин дайчид, тэмцээний зохион байгуулагч, шүүгчид оролцлоо.

Тэмцээнийг нээж Я.Содбаатар хэлсэн үгэндээ “Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлыг батлан хамгаалах, нийгмийн аюулаас сэргийлэх хариуцлагатай үүрэг хүлээсэн алба хаагчдын бие бялдрын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд энэхүү тэмцээн нь асар өндөр ач холбогдолтой юм. Төр, ард түмнийхээ төлөө тангараг өргөж, мөрдэс зүүсэн алба хаагчид маань дэлхийн халуун цэгүүдэд эр зориг, тэсвэр хатуужил, авхаалж самбаагаараа хошуучлан манлайлахад нь “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор” тэмцээн бодит үр дүнгээ өгч байна гэж хэлмээр байна.

Тэрчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн монгол хүний бие бялдрын хөгжлийг сайжруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нийтээрээ эрүүл чийрэг байх, хүүхэд залуучуудыг биеийн тамир спортоор дамжуулан хүмүүжүүлэх, хорт зуршлаас ангид байлгах зорилт бүхий “Нийтийн

биеийн тамирыг хөгжүүлэх тухай” зарлигийг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид манлайлан хэрэгжүүлж байгаад сайшаалтай байна” хэмээгээд нийт баг, тамирчдад өндөр амжилт хүслээ.

Тэмцээн зохион байгуулагчдын мэдээлснээр 5 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд баг, тамирчдын гарааны өмнөх ажиллагаа, гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолт, норматив бэлтгэлүүдийг нь шалгах бол 5 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд гараанаас бариа хүртэлх гол уралдаан явагдана.

Төрийн цэргийн болон хууль сахиулах 12 байгууллагын 800 гаруй алба хаагчид энэ удаа тэсвэр хатуужлаа сорин оролцож байгаа бөгөөд “Байнгын бүрэлдэхүүний салаа”-гаар Зэвсэгт хүчин, ХХЕГ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, ТТХГ, Дотоодын цэргийн штаб, ШШГЕГ гэсэн 8 байгууллага, “Хугацаат цэргийн алба хаагчдын салаа”-гаар ЗХЖШ, ХЗЦК, Дотоодын цэргийн штаб, УБХИС, ДХИС гэсэн 5 байгууллага, “Эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг”-аар Зэвсэгт хүчин, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ, ХХЕГ, ОБЕГ, УБХИС, ДХИС, Дотоод цэргийн штаб гэсэн 9 байгууллага, “Рот”-оор ЗХЖШ, ХЗЦК, ТХЦК-ын нэгтгэл, ангиудын бүрэлдэхүүн оролцож байгаа юм. Тэмцээний Ерөнхий шүүгчээр ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, нарийн бичгийн даргаар ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ нар ажиллаж байна.

Тэмцээний хаалтын ажиллагаа маргааш буюу 24-ны өдөр болж шилдгүүдээ шалгаруулна. Шилдгүүдийн шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх өөрийн биеэр гардуулан өгнө.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|------|
| ☀️ 26 | ☁️ 4 |


ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 41 | ☁️ 28 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|----------|---------|
| USD 🇺🇸 | 3,128.00 | 3,134.0 |
| EUR 🇪🇺 | 3,322.0 | 3,330.0 |
| CNY 🇨🇳 | 467.00 | 469.00 |
| RUB 🇷🇺 | 47.90 | 48.50 |
| JPY 🇯🇵 | 24.30 | 24.70 |
| KRW 🇰🇷 | 2.46 | 2.49 |

ЗУРХАЙ



2022.05.23 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Эд эдлэл идээ ундаа олдоно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.05-20.33
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал: Ус

Энэ өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лусыг тахиx, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдах, сэтгэлд сөвтэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 527,715,302

Эдгэрсэн

Нийт: 497,976,682

Нас барсан

Нийт: 6,300,346

Цахим шууданд

ОЮУТНУУД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР, ЗЭВСЭГТ ХҮЧИНД АЖИЛЛАХ СОНИРХОЛТОЙ БАЙГААГА ИЛЭРХИЙЛЭВ



журмыг ойлгож авдаг. Өмнө нь цэргийн албыг ганцхан хэлбэрээр буюу зөвхөн биеэр хаадаг байсан. Өнөөдөр иргэдэд олон сонголт бий болсон. Үндсэндээ иргэдийн санал сэтгэгдлийг сонсож, эрхгүйн орчныг шинэчлэх хүрээнд Батлан хамгаалах салбарын хуулийн зохицуулалтууд ийм хэлбэрээр сайжирч байгаа. Мөн ёс суртахуун, ёс зүйг

Өнгөрсөн бямба гарагт Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар "Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтын "Цэргийн ерөнхий бэлтгэл" онолын сургалтыг зохион байгуулж буй явц, байдалтай танилцаж, оюутнуудтай уулзлаа.

Тус сургалт Монгол Улсын их сургууль, Шинжлэх



сайтар сахиж, салбарын бие бүрэлдэхүүн хандлагаа өөрчлөх талаар ихээхэн анхаарч ажиллаж байна. Улс орны ирээдүй болсон залуус та бүхэн эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ цэргийн нөхөрлөлийг мэдэрч, алба амжилттай хаахыг хүсье" гэв.

Мөн оюутнууд цэргийн алба хааж, цаашид сургуулиа төгсөөд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн хамт Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, БХЯ-ны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга хурандаа Д.Энхсайхан нарын албаныхан ажиллалаа.

"Оюутан цэрэг" хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр зургаан удаагийн сургалтад 5,000 гаруй оюутан залуус хамрагдаж, цэргийн алба хаасан байна.

ухаан, технологийн их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Монгол Улсын боловсролын их сургуулиудыг түшиглэн зохион байгуулагдаж байна.

Энэ жил анх удаа "E-Mongolia" цахим платформоор бүртгэл явуулж, нийт 1,472 оюутан бүртгүүлснээс голч оноогоор жагсаан, эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад хамруулсан бөгөөд сонгон шалгаруулалтад 400 гаруй оюутан тэнцсэн юм.

Бригадын генерал

Ж.Болдбаатар оюутнуудтай уулзах үеэрээ тэдний санал сэтгэгдлийг сонсож, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлав.

Тэр бээр оюутнуудад хандан "Та бүхэн ирээдүйд өөртөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд, мөн иргэний үүргээ үнэнчээр биелүүлэхээр энэхүү сургалтад хамрагдаж байна.

Тус хөтөлбөрт хамрагдсанаар залууст эх оронч үзэл төлөвшиж, тэдний нийгэм, гэр бүлийн хандлага, хариуцлага сайжирч, хууль

"ГАР БӨМБӨГ"-ИЙН НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



шагналыг энэ сарын 25-нд зохион байгуулагдах "Нээлттэй хаалга"-ны өдрөөр гардуулах аж. Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг Баян-Өлгий аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн хамт олон Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан Баян-өлгий аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд "Гар бөмбөг"-ийн нөхөрсөг тэмцээнийг 2022 энэ сарын 21-ний өдөр эхлүүлээ.

Уг тэмцээнд Баян-өлгий аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нийт 8 баг, тамирчид оролцож байгаа юм. Тэмцээн нээлтийн үйл



ажиллагаанд Баян-Өлгий аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд оролцож баг тамирчдад амжилт хүслээ.

Тэмцээн 3 хоног үргэлжлэх бөгөөд шилдгүүдийн

байгууллагуудын хэмжээнд өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж байгаа нь энхийг сахиулагчдаа алдаршуулах, тэдэнд хүндэтгэл үзүүлэх, энхийг сахиулах ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулах зорилготой юм.

АВЬЯАСЛАГ БАГАЧУУДЫГ ХҮЛЭЭН АВЛАА



ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр "Намуун гоё" цэцэрлэгийн удирдлага хамт олон, хүүхэд багачуудад ангийн товч танилцуулгыг хийсэн бол хугацаат цэргийн алба хаагчид жагсаалын

Зэвсэгт хүчний 032 дугаар ангид

Өнгөрсөн баасан гарагт "Намуун гоё" цэцэрлэгийн удирдлага хамт олон, хөөрхөн бяцхан хүүхэд багачууд Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хүрэлцэн ирж өөрсдийн эрдэм мэдлэг, авьяас чадвараа ангийн удирдлага хамт олонд толилууллаа.

Арга хэмжээнд "Намуун гоё" цэцэрлэгээс гурван бүлгийн жар гаруй авьяаслаг хүүхэд багачууд хүрэлцэн ирж "Манай цэцэрлэг", "Би цэрэг" дуунуудаар ангийн нийт бие



бүрэлдэхүүнд ая дууны үзүүлэх тоглолтоор бэлэг мэндчилгээ дэвшүүлээ.

Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 032 дугаар

Ахлах дэслэгч Т.ДЭЛГЭРМАА

"ОНЖАВУУД" ТӨГӨЛ БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлээд байна. Энэхүү үндэсний хөдөлгөөнийг



хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Зэвсэгт хүчний 120 дугаар ангид дүүргээс татагдан алба хааж байгаа дайчдад зориулан

"Онжавууд" төгөл байгууллаа.

Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын зөвлөх Н.Бямбагэрэл, Цэргийн штабын дарга О.Мөнхжаргал, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч, хурандаа

Л.Дагвасүрэн, захирагчийн орлогч дэд хурандаа Г.Баярхүү болон ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцлоо.

Нээлтийн үеэр Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч Л.Дагвасүрэн хэлэхдээ "Тариад орхих бус арчлан хамгаалж, усалж, ургуулах ажлыг манай ангийн хамт олон тэр дундаа Чингэлтэй дүүргээс татагдан алба хааж буй байлдагч түрүүч нар арчлан хамгаалах болно. Мөн жил бүр Чингэлтэй дүүргээс татагдаж ирж буй цэргүүд "Онжавууд" төглөө илүү томруулж ажиллана гэж итгэж байна" гэж хэллээ.

Энэ үеэр ангид 100 ширхэг хайлаас модыг ангийн шалган нэвтрүүлэх байрны гадна талбайд ангийн офицер, ахлагч, түрүүч, байлдагч нар суулгаж тарилаа.

УРЛАГИЙН НААДАМД ТЭРГҮҮЛСЭН ШИЛДГҮҮДИЙН "НЭГДСЭН ГАЛА ТОГЛОЛТ" БОЛЛОО



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101, Налайх дүүрэг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг тохиолдуулан тус дүүрэг дэх Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "Налайхын цэнхэр хөндий" урлагийн наадмын тэмцээнд

тэргүүлсэн анги байгууллагуудын "Нэгдсэн гала тоглолт"-нд ангийн бие бүрэлдэхүүн амжилттай оролцож байна.

Тус тоглолт нь энэ сарын 17, 18, 19-ний өдрүүдэд Налайх, Багахангай, Багануур дүүргүүдэд тоглогдож байгаа бөгөөд Зэвсэгт хүчний 014, 350, 353 дугаар ангиуд болон Налайх дүүргийн соёлын ордны уран бүтээлчид оролцсон юм. "Нэгдсэн гала тоглолт"-оос олсон орлогыг Налайх дүүргийн

"Монгол цэргийн холбоо" ТББ-ын танхимыг тохижуулах, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, дэд хурандаа Б.Ууганбаяр, түүний гэргий Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 22 дугаар ангийн дуудлага хүлээн авагч, ахлагч С.Ганзаяа нарын гурван настай охин У.Маргадын БНСУ-д хийлгэх яаралтай мөс заслын эмчилгээнд хандивлах юм.

Дэслэгч Р.БИЛЭГ